

МУИС Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль

ЛИНГВИСТИК ЭРГЭЛГЭЭС
ПОСТМОДЕРНИЗМ ХҮРТЭЛ

Ц.НЯМСҮРЭН
ЭМШУИС. НХУ-ны тэнхим

Түлхүүр үг:

Структурализм, хэл, яриа, постструктурализм, деконструкци, ялгаа, постмодернизм.

Товч агуулга:

Энэхүү өгүүлэлд структурализмаас постмодернизм хүртэлх үзэл сургаалыг асуудалд хандах өвөрмөц хандлагаар нь дамжуулан товчлон тайлбарласан болно.

Социаль бүтцийг анхаардаг функционализм, марксизм зэрэг хандлага урьд өмнө байсан ч хэлний бүтцийг чухалчилдаг структурализм гарч ирснээр нийгэм, хүмүүнлэгийн ухаануудын мөн чанар эрс өөрчлөгдсөн юм. Энэхүү шилжилтийг өнөөдөр лингвистик эргэлт хэмээн нэрлэдэг.

Орчин цагийн структурализмын эх булаг, бат бэх хэрэм нь өнөө хүртэл хэл шинжлэл байсаар иржээ. Шведийн хэл шинжээч **Фердинанд де Сюссор** /1857-1913/ структурализмыг хэл шинжлэлийн хүрээнд анх хэрэглэсэн бөгөөд үүнээс хойш структурализм нь антропологи гэх мэт нийгэм хүмүүнлэгийн бусад ухаанд нэвтэрсэн юм. Сюссорын үндсэн санаа нь үг дангаараа байхдаа утгаа бүрэн илэрхийлдэггүй харин өгүүлбэрт /өөрөөр хэлбэл бүтцэд/ орж байж, бусдаас ялгарах ялгаанаасаа л утгаа олдог гэдэгт оршино. Тэрээр хэлийг формаль талаас нь өөрөөр хэлбэл диахрон /динамик/ гэхээсээ синхрон /статик/ гэж тодорхойлогдохуйц тэмдгийн систем болох хувьд нь судласан. Тэмдэг нь тэмдэглэгч /авиан эсвэл график тохирох дүрслэл/, тэмдэглэгдэгч /ойлголт эсвэл утга/-с тогтоно. Түүнийхээр л-и-й-р гэсэн үсгээс тогтсон үг модонд ургадаг нэгэн төрлийн жимсний, тодруулбал лийрний ойлголтыг бидэнд төрүүлдэг. Эндээс үг нь ойлголтыг л илэрхийлэхээс юмсыг илэрхийлэхгүй гэсэн санаа урган гарна. Тэмдэглэгч, тэмдэглэгдэгчийн харилцаа дор хаяж хоёр утгаар зохиомол шинжтэй. Нэгд, эдгээр дүрслэл /л-и-й-р/ яагаад лийр гэсэн ойлголтыг тэмдэглэх ёстой вэ гэдэгт зайлшгүй шалтгаан байхгүй. Хоёрт, лийр лийр гэсэн үг лийр гэдэг зүйлтэй огт адилгүй. Тэгэхээр тэмдэглэгч, тэмдэглэгдэгчийн холбоо конвенциаль шинжтэй. Гэхдээ лийр гэдэг үг лийр гэсэн ойлголтыг тэмдэглэхийн тулд л бий болсон, хэн ч үүнийг дураараа өөрчлөх чадалгүй өөрөөр хэлбэл энэ харилцаа зарим утгаар /уг гарвалын тухайд бол/ тохиолдлын шинжтэй, зарим утгаар /хэрэглээний тухайдаа/ тийм биш.

Тэмдэг өөрөө ч санамсаргүй шинжтэйг тэрээр онцолсон. Тэмдэг /тэмдэглэгч, тэмдэглэгдэгчийн хослол/ нь тэмдэглэж буй зүйл /референт буюу физик тухайн биет/ хоорондын холбоо ч дурын шинжтэй. Хэн нэг нь тухайн ойлголт шууд ба шууд бусаар бодит лийрнээс үүсдэг гэж эсэргүүцэж болно. Бүр бодит лийрний шинж тэмдэгүүд лийрний тухай ойлголттой шалтгаант байдлаар холбогдоно гэж хэлж ч болно. Гэхдээ Сюссор хэлний хэрэглээнд биш, харин бүтцэнд /structure/ анхаарлаа хандуулсан гэдгийг дээрх эсэргүүцлийн хариуд хэлье. Сюссор аман ярианд илэрч хэрэгждэг хэлийг /parole/ хашилтанд авч хэлний формал бүтцээр /langue/ судалгаагаа хязгаарласан юм. Үүнээс бүтэцлэх буюу структурализм хэмээх нэр томъёо гарчээ. Тэрээр тэмдгийн хамаарах бодит материаллаг объекттой холбоотой судалгааг хойш тавьсан хэрэг. Энэ нь оюун ухаанд төсөөлөгдөж буй зүйлийг судлах боломжийг бүрдүүлж, энэ утгаараа түүний хандлага Хүссэрлийнхтэй адил. Сюссорын хэл шинжлэлээр бол тэмдгийн системийн тэмдэг бүр өөр бусад тэмдэгээс ялгарах ялгаанаасаа утгаа олдог. "Лийр" гэдэг үг дангаараа буюу өгүүлэгчийн санаанд утгатай байдаггүй, харин боломжит бусад бүх дүрслэлээс жишээ нь н-а-в-ч, а-л-и-м, а-н-и-с гэх мэтээс ялгарч байгаа учраас л утгатай болдог. Структурализмын хувьд утга нь системийн /хэлний/ доторх элемент /тэмдэг/ хоорондын ялгаанаас үүсдэг. Эдийн засгийн аналогийн Сюссорын утгын онолыг тодорхой төсөөлөхөд тус болно. Хэлний системийн тэмдгийг мөнгөн системийн дэвсгэрттэй адилтгая. Хэлний систем үнийн системтэй адилхан. 100-тын дэвсгэрт арилжааны үнэлэмжээрээ тодорхойлогдсон мөнгөн үнэлгээтэй. 100-тын дэвсгэртүүд зохиомол /тохируулж болохуйц/ үнэлгээтэй учир тэднийг бусад зүйлээр арилжиж болно. Бараа бүтээгдэхүүн худалдан авахдаа тэднийг ийн хэрэглэдэг. Гэхдээ тэд бусад мөнгөн дэвсгэрттэй харьцуулахад тогтсон үнэтэй. Жишээ нь, 100-тын дэвсгэрт нь 50-тын хоёр дэвсгэрттэй эсвэл 20-тын таван дэвсгэрттэй тэнцүү, тэр нь 50-таас их 500-таас бага. Хэлний тэмдэг нь бусад тэмдэгтэй харьцуулахад бас л үнэтэй буюу утгатай. Тэдний хувьд адил тэнцүү солилцоо ч бий. Жишээ нь, "ганц бие" гэхийг "гэрлээгүй" гэдгээр сольж болно.

Яваандаа бүтцийг хэлнээс гадуур тэмдгийн бүх системийн судалгаанд хэрэглэх болжээ. Тэмдгийн системийн бүтцийг онцгойлох хандлагыг семиотикийн гэж нэрлэж байна. Семиотик нь зөвхөн хэлийг төдийгүй тэмдэгийн бусад системийг жишээ нь нүүрний кувирал, биеийн хөдөлгөөн,

уран зохиолын текст, үнэндээ харилцааны бүх хэлбэрийг хамардаг болохоор структуралист хэл шинжлэлээс өргөн.

Ролан Бартыг семиотекийн жинхэнэ үндэслэгч гэж тооцох нь олонтоо. Тэрээр Сюссорын санааг нийгмийн амьдралын бүх хүрээнд түгээсэн. Дан ганц хэл төдийгүй нийгмийн зан үйлүүд ч төлөөлөл буюу тэмдэг юм. "Хэл төдийгүй бөхийн тэмцээн ч бас тэмдэглэгч зүйл, үүнчлэн телевизийн шоу, хувцас, хоол хийх, ер нь өдөр тутмын амьдралын бүх зүйл мөн адил". Ийн лингвистик эргэлт нь өөрийн ээлжинд тэмдэг гэж тайлбарлагдах нийгмийн бүх үзэгдэлд хамаарах болжээ. Р.Барт 1968 онд бичсэн *Зохиолчийн үхэл* өгүүлэлдээ судалгаанд зохиогч гол байр суурьтай байдгийн эсрэг хүчтэй, маргаантай үндэслэл дэвшүүлсэн юм. Энэ өгүүллийн "Зохиогчийн үхэл бол уншигчийн төрөлт" /Уншигч төрөх нь зохиогчийн үхлийн үнэтэй/ гэсэн сүүлчийн өгүүлбэр хожим их эшлэгдсэн. Утгыг бүтээхэд уншигчид илүү их үүрэг оноосоноороо уран зохиолын бүтээлийг тайлбарлагдах гэж бүтээгддэг гэж харах нөхцлийг бүрдүүлжээ. /Хожим Фуко түүний маргаанд *Зохиогч гэж хэн бэ?* өгүүллээрээ хариу өгсөн/ 1971 оны *Зохиолоос Текст* хүртэл хэмээх өгүүлэлдээ зохиол нь /ном эсвэл кино/ зохиогч руу ямарч асуудалгүйгээр дагуулдаг /иймд хаалттай/ утгыг агуулдаг бол текст нь /мөн ном эсвэл кино/ нээлттэй байдаг зүйл гэж үзсэн. Түүний S/Z бүтээлийг уран зохиолын структуралист шүүмжлэлийн сод бүтээл гэж үнэлдэг. Үүндээ зохиолыг уншигдахуйц ба бичиглэхүйц гэж ангилсан. Мифологиудаа амьтны хүрээлэнгээс музей, хувцас хүртэлх соёлын объектуудыг товч, тодорхой задлан шинжилжээ.

Структурализмыг хөгжүүлсэнээрээ XX зууны сэтгэлгээнд өөрийн байр сууриа эзэлсэн өөр нэг сэтгэгч бол францын антропологич **Клауд Леви Страусс** юм. *Ураг төрлийн энгийн бүтцүүд* (1949) бүтээлийг нь Баувор өрнийн бус соёл дах эмэгтэй хүний байр суурийн тухай чухал үнэлгээ гэж үзсэн. Хүмүүс гэр бүлээ хэрхэн зохион байгуулдагыг агуулга гэхээсээ харилцаан дээр үндэслэсэн логик бүтцийг илрүүлэх замаар судласан. Радклифф Браун ураг төрлийг угсаа гарвал дээр суурилдаг гэсэн бол Страусс нэг овгийн эмэгтэй нөгөө овгийн эрэгтэйтэй гэрлэх үед үүсдэг гэр бүл хоорондын харилцаан дээр тогтдог гэж үзжээ. 1962 онд *Зэрлэг сэтгэлгээ* хэмээх бүтээлээ хэвлүүлсэн. Энэ номын эхний хагас нь соёлын онол, оюун ухааны талаарх түүний онолыг бүрдүүлдэг бол сүүлийн хэсэг нь үүнийг түүх, нийгмийн өөрчлөлтийн онол болтол нь өргөтгөдөг. Энэ хэсэг нь хүний эрх чөлөө, мөн чанарын талаар Сартртай маргасан шинжтэй байв. Нэг талаас экзистенциал философи нь Сартрыг хүн бол сонгосоноороо

үйлдэх эрхтэй гэж хэлэхэд хүргэдэг. Гэвч нөгөө талаас тэрээр хувь хүн бол өөрт нь хүчтэй нөлөөлдөг үзэл сурталд баригддаг гэж үздэг зүүний үзэлтэй нэгэн байлаа. Страусс структуралист үзлээ Сартрын эсрэг хандуулсан. 1960-д оны сүүлээс *Мифологиуд* бүтээл дээрээ ажилласан. Үүндээ өмнөд америкийн урд хэсгээс нэг домгийг сонгон авч бүхий л хувилбарыг нь нийт америк тивээр мөшгөсөн байна. Үлгэрүүдийн агуулгад биш, харин бүрдэл хоорондынх нь харилцааны бүтцэд онцгойлон анхаарчээ.

Эхэндээ хэл шинжлэлээс ялангуяа фонетикоос () адилтгал жишээ татдаг байснаа хожим хөгжим, математик, кибернетикээс авдаг болсон юм. Жинхэнэ шинжлэх ухааны задлан шинжилгээ бодитой, энгийн, тайлбарт шинжтэй байх ёстой гэж тэрээр үзсэн. Фономик¹ задлан шинжилгээ бодитой байх шинжийг хангахаас гадна энгийн байна. Учир нь хэлний авиан фономик бүтэц харьцангуй цөөн дүрмээс тогтдог.

Яагаад ураг төрлийн харилцаа соёл бүхэнд өөр байгааг судласан. Нэг тохиолдолд эцэг нь хүүгээ захирдаг байхад нөгөөд нь нагац ах захирах жишээтэй. Эхлээд ураг төрлийн систем дэх бүх гишүүдийг хэд хэдэн хэмжигдэхүүнээр эрэмбэлсэн. Жишээ нь, эцэг нь хүүгээсээ ах, түүнийг төрүүлсэн, түүнтэй ижил хүйстэй, нагац ах нь хүүгээс ах, түүнтэй ижил хүйстэй боловч түүнийг төрүүлээгүй гэх мэтээр эрэмбэлсэн. Гэхдээ хүснэгт дэх үр дүн нь эх баримтыг ойлгохоос ч төвөгтэй, дурын хийсвэрлэлд тулгуурласан шинжтэй. Эцэг нь хүүгээсээ ах гэдэг нь харилцааг тайлбарлахгүй. Үүнийг шийдэхийн тулд ураг төрлийн үндсэн нэгжийг олох хэрэгтэй. Цус ойртолтын хорио бүхий бүх нийгэмд аав, ээж, ах, эгч, хүүгийн үүрэг заавал хэрэгждэг.

Залуу хосуудын солилцоог үгийн солилцооны адилаар шинжилж болно. Ураг төрлийг тодорхойлоход хэрэглэгдэж буй нэр томъёо нь хэлний фонемууд шиг анализын үндсэн нэгж. Аль ч нэгж нь дангаараа утгагүй, харин системийн холбоот хэсэг болохдоо л утгатай болдог. Аль алинд нь эмпирик, далд ялгаа байж болох ч нэг ерөнхий хуулинд захирагдана. Лингвистик эргэлтэнд өвөрмөц санаа оруулсан нь аль ч системийг оюун ухааны бүтцийн илрэл гэж үзсэн явдал юм. Эдгээр систем өөрийг нь үүсгэж буй оюун ухааны логик нэг ерөнхий хуулин дээр хэрэгждэг.

Түүнийхээр тэмдэглэгч бүх систем агуулгыг нь эс тооцвол суурь ижил бүтэцтэй. Бидэнд юу ижил байгааг илрүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлсэн

¹ фоно-дуу авиан (энд тэмдэг нэрийн утгаар хэрэглэгдэж байна)

гэсэн үг. Хүний нийгэм бүрийн үндсэн нэг бүтэц нь ураг төрлийн хэлхээ. Аль ч нийгэмд хэн хэнтэй гэрлэж болох, хэнээс юуг авах, энэ бүх харилцааг юу гэж нэрлэхийг шийддэг систем байдаг. Ураг төрлийн систем хэл шиг үндсэн нэгжтэй, эдгээр нэгжийг холбох дүрэмтэй. Түүнийхээр ураг төрлийн бүтэц эд хөрөнгө, үзэл санаа, хүн соёлын дотор хэрхэн "арилжаалагдахыг" тогтоодог.

Бүтэц дэх нэгж хоорондын харилцааг бие биетэйгээ ижил ч байдаг, ялгаатай ч байдаг бинар хосоор илэрхийлсэн. Энэ нь нэг зүйл ижлээрээ солигддог гэх Сюссорын парадигмын санаа, мөн нэг зүйлийг өөр нэгнээр солих синтагмын санаатай холбоотой. Энэ нь бас метафор /ижилсүүлэл/, метономи /зүйрлэл/-н санаатай холбоотой. Метафор хоёр зүйл хоорондын ижил шинжийн харилцааг тогтоодог /А нь Б-тэй ижил буюу А бол Б/ бол метономи нь ямар нэг зүйлийг ойролцоо, холбостой боловч адил бишээр нь /хаан гэхийн оронд титэм гэж хэлж/ орлуулдаг. Үүнд системийн нэгж хоорондын харилцаа гагцхүү хос байдлаар шинжлэгддэгт гол санаа оршино. Бид А бол А гэдгийг мэднэ учир нь энэ нь Б биш, К биш, % биш, гэхдээ бид А юу болохыг А:Б, А:К, А:% гэсэн бинар хосоор л судлаж чадна. Өөрөөр хэлбэл Страуссын хувьд аливаа тусгаар нэгжийн жинхэнэ байдал буюу А юу вэ гэдэг нь хамаагүй харин бинар хос болгон харьцуулж буй дурын хоёр нэгж хоорондын харилцаа л чухал байсан.

Бинар хосоос нэгийг нь таалж, нөгөөг нь таалдаггүй нь бас л чухал. Жишээ нь, болсон нь түүхийгээс сайн, сайн нь муугаас дээр, гэрэл нь харанхуйнаас илүү гэх мэт.

Домог бол хэл, учир нь тэр оршин байхын тулд яригддаг. Хэл болох хувьдаа домог нь "бичиг/langue/", "яриа/parole/" хоёроос тогтоно. Страусс бичгийг "ухардаг цаг" гээчтэй, яриаг "үл ухрах цаг" гээчтэй холбон тайлбарласан. Яриа буюу үйл явдал нь шугаман цагт оршдог. Энэ цагийг ухрааж чадахгүй. Бичиг өөрөө бүтэц учраас өнгөрсөн, одоо, ирээдүйд оршино. Домог ихэвчлэн эрт үед үүссэн учраас түүхэн, гэвч түүний агуулга нь цаглашгүй буюу түүхэн бус. Түүх болох хувьдаа домог бол яриа, цаглашгүй хувьдаа бичиг. Домог үндсэн хэлбэр буюу бүтцээ алдахгүйгээр орчуулагдаж, танагдаж, нэмэгдэж, олширч чаддаг. Домгийн бүтэц илүү дээд, нарийн түвшинд хэрэгждэг. Домог нь хэлтэй дараах шинжийг хуваалцдаг.

1. Хамтдаа тодорхой дүрэмд нийцсэн нэгжүүдээс тогтдог.
2. Эдгээр нэгж нь бүтцийн үндэсийг хангах бинар хос буюу харшуулал дээр суурилсан харилцааг өөр хоорондоо үүсгэдэг.

Домог нь хэлнээс ялгаатай, учир нь түүний нэгж нь мифем¹ юм. Домгийг шинжлэхдээ нарийн ба бүдүүн түлхүүр бүхий хөгжмийн тэмдэглэгээг жишээ болгосон. Аяыг диахрон байдлаар, зүүнээс баруун тийш, хуудас хуудсаар тоглож болдог. Бас нарийн түлхүүр болон бүдүүн түлхүүртэй холбогдох холбоог нь харж синхрсн байдлаар ч аяыг тоглож болно. Нарийн, бүдүүн түлхүүр нотны холбоо (буюу зохицол "багц холбоо" үүсгэдэг. Домгийг хамгийн бага бүрдэл хэсэг (буюу мифемүүдэд задлана. Нэг мифем нь нэг үйл явдал юмуу нэг байрлалыг тодорхойлно. Тэднийг диахран байдлаар ч, синхрон байдлаар ч уншигдахаар байршуулна. Домгийн өгүүлэмж нь диахрон /зүүнээс баруун/ тэнхлэг дээр, үл ухрах цагт байрлана. Домгийн бүтэц синхрон /дээрээс доош/ тэнхлэгт, урхах цагт оршино. Одоо домгийн стандарт бүтцийг авч үзье: баатар маань бэрхшээлтэй учрана, түүнийг давж, зарим /эерэг/ үр дүн олж авна. Одоо энэ домогт хамаарах задаргаагаа буулгах хэрэгтэй. Ингээд бид энэ домгийн бүх хувилбарыг: баатар маань хэн болох, бэрхшээл нь юу байсан, түүнийг яаж даван гарсан, ямар үр дүн олсоныг самбар дээр жагсаана. Хувилбар бүрийн бүтэц адилхан байв ч хувилбар бүхэн хосгүй. Страусс хувилбарын босоо баганыг хараад бүх хувилбарт хамаарах зарим нэг логикуыг илрүүлнэ. Тохиолдол бүрт бүрэн бус зүйл, баатар маань бэрхшээлийг даван туулахад хэрэгтэй зүйл байна. "Бүрэн бус", "бүрэн" хоорондын зөрчил нь шийдэхийг оролдож буй домгийн маань хувилбар бүрийн дилемм юм.

Структурализмын өөр нэг хувилбар нь структуралист марксизм ялангуяа **Лүюис Алтүссер, Никос Роуланцас, Маурийс Гүдэлиэр** нарын бүтээл байв. Тэдний зарим нь бүтцийн судалгааг түүхийн судалгаанаас урьддаг гэж ойлгодог. Бүтцийн дотоод функцижилтын судалгаа үүсэл, хувьслынх нь судалгаанаас өмнө хийгдэх ёстой гэж Гүдэлиэр үзсэн. Тэрээр "системүүдийн дотоод логик үүслийнх нь судалгаанаас өмнө хийгдэх ёстой"² гэж бичжээ. /Үүнийг Хегелийн оюун санааны феноменологитой адилтгаж болмоор байна. Логик-байгаль-оюун санаа гэсэн дараалал энд илэрдэг. Харин Фуко үүний эсрэг түүхийг голлосон, иймд структурализмын эсрэг юм. Ц.Н/ Тэд нийгмийн бүтцийг юу бүрдүүлдэг вэ гэдгийн эмпирик тодорхойлолтуудыг үгүйсгэдэг. Харагдаж буй зүйл нь өөр, далд бодит байдлыг нууж буй бодит байдал юм. Гэхдээ тэд лингвистик эргэлтэнд төдий л оролцоогүй.

¹ Домгийг бүрдүүлэгч үйл явдал гэсэн утгаар ойлгож болно.

² Godelier Maurice *Rationality and Irrationality in Economics*. London: NLB. 1972, pp., xxi

Структуралист онолын нөлөө

Энэ онол ёсоор утга бол Хүссэрлийн бодсончлон хувийн туршлага биш, утгын нийтлэг системийн бүтээгдэхүүн байдгийг эхлээд онцлох хэрэгтэй. Текст нь системийн өөрийнх нь далд бүтцээр шинжлэх ухаанчаар задлан шинжилж, тайлбарлагдах хийц гэж ойлгогдоно.

Хоёрд, структурализмд тусгаар хүн бол системийг бүтээгч гэхээсээ илүүгээр түүний бүтээл байдгийг тэмдэглэх хэрэгтэй. Хэл биднээс урьддаг. Хэл бол бодол, туршлагын зууч. Тиймээс хэл нь бид туршлагаа ойлголтжуулахдаа хэрэглэдэг тэр бүтцээр биднийг хангадаг.

Гуравт, хэл дурын шинжтэй болохоор үг, юм хооронд **төрөлх холбоо** байхгүй, хэл бодит байдал хооронд ч онцгой холбоо байдаггүй. Энэ утгаар бодит байдал мөн хэлээр бүтээгддэг. Ийн структурализм идеализмын нэг хэлбэр гэж ойлгогдоно.

Эндээс структурализм нь бидний мэдэрч хүртэж буй зүйл бодитой гэдэг эмпиризмийн шаардлагыг нураадаг нь тодорхой байна. Мөн ердийн ухамсарыг ялангуяа текст нь утгатай гэдэг үзлийг дайрч буй юм. Гэхдээ ердийн ухамсартай зөрчилдөх байдлыг өөр бусад түүхэн зөрчилтэй харьцуулбал аятайхан /жишээ нь, Коперникийн нар төвт систем/. Өөрөөр хэлбэл юмс бидэнд харагддаг шигээ байдаггүй. Структурализмын идеалист шаардлагыг дараах байдлаар ойлгож болно. Бодит байдал болон түүний тухай бидний ойлгохуй "тасархай". Энэ үзэл бидний дор авч үзэх чухал нөлөөг үзүүлсэн.

Структуралист онолоор текст юмуу хэллэг нь утгатай, гэхдээ түүний утга нь түүнийг хэлэгчийн сэтгэлзүйн төлөв, "зорилго"-р тодорхойлогдохгүй харин түүний илэрч буй хэлний системийн далд бүтцээр тодорхойлогдоно. Энэ утгаар субъект /зохиогч/ дүрмийн автомат систем болох хэлэнд бут цохиулж, түүнд байраа тавьж өгсөн. Үүгээрээ антигуманист шинжтэй. Уг онол Коперник Дэлхийг нарны систем дэх төв байрнаас нь хөдөлгөж /төв биш болгосон/ шиг субъектыг утга бүтээхүйд эзэлдэг гол үүргээс нь чөлөөлсөн. Нэгэнт хэл биднээс өмнө оршдог болохоор хэлээр бид ярьдаг биш, Хайдеггерийн хэлсэнчлэн "хэл биднийг яриулдаг".

Постструктурализм

Деррида хэлийг субъектээ дарамталдаггүй "бичиг" болтол нь өөрчилсөн. Хэдийгээр хэлийг энд авч үзэж буй боловч бичиг бол хүнийг дарамталдаг бүтэц биш юм. Структуралистууд хэлний системээс эмх цэгц, тогтвортой байдлыг хайдаг бол Деррида хэлийг эмх цэгцгүй, тогтворгүй болгож харсан. Ялгаатай контекстүүд үгэнд ялгаатай утга өгдөг. Иймд

хэлний систем структуралистуудын бодсончлон хүнийг хазаарлах хүчгүй. Хэлний суурь хуулийг хайх нь боломжгүй. Дерридагийн тэмцлийн бай нь өрнийн сэтгэлгээнд ноёрхсон логоцентризм байлаа. Деррида үүнийг "Платоноос хойш бичгийг хорьж дарангуйлсан түүхэн хорио, дарангуйлал"¹ гэж тодорхойлсон. Деррида бичгийг боолчлолч зүйлээс нь чөлөөлөхийг хүссэн. Түүний эрэгцүүллийн маш тодорхой жишээ бол "балмад үзэгдлийн театр" хэмээн зүйл юм. Энэ ойлголтыг тэрээр төлөөллийн логик гэгчид захируулсан уламжлалт театрыг шүүмжлэхдээ хэрэглэсэн. Тайзан дээр болж буй бүхэн нь "бодит байдал" дээр болж буйг мөн зохиогч, найруулагч зэргийн бодсон санасаныг "төлөөлдөг". Энэ "репрезентацизм" нь мөнөөх театрын бурхан бөгөөд уламжлалт театрыг теслогийн болгодог. Теологийн театр бол удирддагддаг, боолчлогдсон театр. "Энэ театрын тайз нь уламжлалыг бүхэлд нь дагаж, эзгүй, хол байгаа, текстээр зэвсэглэсэн, цагийг тааруулдаг, төлөөллийн утгыг бий болгодог, тохируулдаг зохиогч хэмээх бүтээгчийг шүтдэг хувьдаа теологи шинжтэй. Тэрээр "бүтээгчийн" бодол санааг их бага хэмжээгээр шууд төлөөлдөг төлөөлөгч, найруулагч юмуу жүжигчин, боолчлогдсон тайлбарлагчдаар төлөөллийг хэрэгжүүлдэг. Үнэнч мөнөөх тайлбарлагч боол "эзний" хүслийг үг дуугүй биелүүлнэ...Эцсийн дүндээ теологи тайз бол идэвхгүй, жирийн үзэгч, хэрэглэгч, сонирхогчдод л таарна"². Тэрээр "үг яриа тайзыг захирдаггүй" тийм тайзыг санал болгосон. Өөрөөр хэлбэл энэ тайзыг зохиогч, текст удирдаж чадахгүй гэсэн үг. Жүжигчид заавар авахгүй, зохиогчид тайзан дээр юу болохыг бүрэн зааж чадахгүй. Гэхдээ энэ нь анархи байна гэсэн үг биш. "Балмад үзэгдлийн театр нь ялгааны урлаг, хэмнэлтгүй, тайлбаргүй, эргэлт буцалтгүй, түүхгүй үрэлгэн байдлын урлаг байх байхаа". Зохиогчийн зааварчилгаанаас ангид театр байх ёстой. Ноёлогч дискурсыг бүтээгч оюуны тэргүүлэгчдийн санаанаас ангид байхыг сурталчилсан. Тодруулбол бид бүгдээрээ зохиогч байх эрхтэй. Өөр нэг ойлголт нь төвийг эвдэх. Зохиогчид төвлөрдөг уламжлалт төвөөсөө хөндийрч, жүжигчинд чөлөөтэй тоглох боломж олгохыг эрмэлзсэн. Тоглолт, ялгаа байхгүй /давтолтын/ театр бол тогтонги, үхмэл театр юм. Хариулт гэдэг бол төв. Аливааг төвгүй буюу хариултгүй орхих нь чухал. Ирээдүй биднийг хүлээж байдаг биш, эргэн олддог юм биш. Бид ирээдүйг өнгөрсөнөөс олохгүй, хувь заяагаа зүгээр

¹ Derrida Jacques *Writing and Difference*. Chacago: University of Chicago Press, 1978. pp., 196

² Derrida Jacques *Writing and Difference*. Chacago: University of Chicago Press, 1978. pp., 235

хүлээж суух учиргүй. Ирээдүй бидний хийж буй зүйлд бичигдэж, бүтээгдэж, нээгдэж байдаг.

Аливаа текстэнд интринсик (дотоод) мөн чанар гэж байхгүй, зөвхөн ялгааны хэлцэл бий. Энэ нь өөрчлөлт хувиралт бодтой, генетик популяцид тогтоосон хэм хэмжээ байдаггүй, хар цагаан хоёрын ялгаа нь нөхцлөөс хамаарна гэсэн санаатай адил. Тэрээр аливаа хүчирхийллийн ялангуяа дискурсын хүчирхийллийн эсрэг.

Түүнээс гадна постструктурализм ойлголт бол үгнээс өөр зүйл биш гэдэг. Онолын энэ шилжилтийг илэрхийлэхийн тулд Деррида ялгаа гэсэн үгийг оруулж ирсэн билээ.

Фукогийн санаа

Фукогийн үзэл хандлагад олон тооны онолын баримжаа өвөрмөц хэлбэртэйгээр илэрдэг. Веберийн рациональчлал байдаг ч тэр нь тодорхой хэсэгт л илэрдэг. Марксын санааг олж түүнээс болох ч тэрээр социаль түвшин дэх эрх мэдлийн тухай уламжлалт хандлагаас илүүгээр эрх мэдлийн микро бодлогыг сонирхсон. Герменевтик, феноменологи, структурализмын нөлөө ч бий. Эрх мэдэл, эрдэм мэдлэгийн харилцааг сонирхсон Ницшегийн хандлагыг өвлөсөн ч энэ холбоог социологийн үүднээс шинжилсэн. Аргагүйн эхэн үеийн ажлууддаа "мэдлэгийн археологий" бүтээсэн. Энэ археологи "өгөгдсөн аливаа цаг үед тодорхой дискурсын дотор өгүүлэгдэж чадах бүхний хувьд боломжит нөхцлийг нь тодорхойлдог хэлбэршүүлэх цогц дүрмийн"¹ хайгуул байв. Фукогийн хожуу үеийнх нь баримжааг "эрх мэдлийн генеалоги" гэдгээр илэрхийлж болно. Үүгээрээ хүмүүс өөрийгөө болон бусдын мэдлэгийн бүтээгдэхүүнээр хэрхэн жолооддогийг сонирхжээ. *Солиорол ба иргэншил* бүтээлдээ сэтгэц эмгэгийн археологи хийсэн. Тэрээр солиорол, оюун ухааныг ялгадаггүй байсан сэргэн мандалтаас эхэлсэн. 1650-1800 онд /сонгодог үед/ тэднийг зааглах болж, эцэст нь оюун ухаан солиорлыг шийддэг болсон өөрөөр хэлбэл оюун ухаан, солиорлын хооронд "үл ойлголцох яриа" үүссэн. Орчин үеийн /19-р зуун/ шинжлэх ухаанч психологи солиорлын тухай оюун ухааны "монологи"² болж хувирчээ. Эхэндээ анагаах ухаан солиорлыг физик болон ёс суртахууны талаас эмчлэхийг оролддог байснаа хожим ёс суртахууны эмчилгээг хаях болсон. Психологи бол ёс суртахууны үйл болохоос шинжлэх ухаанч чармайлт биш. Анагаах ухаанд бүтэц гэж байхгүй. Фуко харц /gaze/ гэсэн нэр томъёо хэрэглэсэн. Тэрээр харцыг хэлний нэг төрөл, "үгүй хэл" гэж үзсэн. Тэгээд

¹ Sheridan Alan Michel Foucault: *The Will to Truth*. London, Tavistock, 1980, pp., 48

² моно-ганд, логос-үг: энд ганцаараа ярих яриа гэдэг утгаар хэрэглэгдэж байна.

энэ хэлний далд бүтцийг сонирхсон. Өвчтэй (үхсэн) хүнийг харж, хүрч мэдрэх чадвар бол мэдлэгийн чухал эх сурвалж. Задлан шинжилгээг өрнийн анагаах ухаан дэх их үсрэлт гэж тооцжээ. Эмч нар нэг л тоглоомсоор тоглохоо больж, өөр дүрэмтэй өөр тоглоомоор тоглох болов. Тоглоом нь /өвчний оронд/ шинжлэх ухааны мэдлэг, дадлагын объект болсон хүн байлаа. Задлан шинжилгээний тухай хэлэхдээ тэрээр "үхэл урьдын эмгэнэлт амар амгалан байхаа больж, түүний үл үзэгдэх үнэн, үзэгдэх нууц нь хүний тухай уянгын цөм болсон" гэжээ. *Сахилга ба шийтгэл* бүтээлдээ эрүү шүүлтээс дүрэм журамд шилжсэн нь гэмт хэрэгтнийг эмчлэх хүмүүнлэг байдлыг төлөөлдөгийг авч үзсэн. Гэхдээ шийтгэл рационалжсан байна. Эрүүдэлтийн хувьд мэдлэг, эрх мэдлийн холбоо илт байдаг бол дүрэм журам хөгжсөнөөр тодорхой бус болсон. Эрүүдэлтээс шоронгийн дүрэм журамд шилжсэн нь биеийн шийтгэлээс сэтгэл, зоришийн шийтгэлд шилжсэн хэрэг гэж үзсэн юм. *Бэлгийн амьдралын түүх*дээ секс бол хүчний харилцааны хувьд онцгой дамжуулагч гэсэн. 19-р зууны сүүлээр нийгэм үхлийг хянахыг оролддог байсан бол энэ зууны эхэнд амьдралыг ялангуяа сексийг хянахад чиглэлээ. Амьдралыг хянах хүч хоёр хэлбэртэй. Нэг нь хүний бие /секс/-г хянах, удирдах "хүний биеийн анатоми-политик", нөгөө нь хүн амны өсөлт, эрүүл мэнд, амьдрал гэх мэтийг хянах зорилготой "хүн амын био-политик". Аль ч тохиолдолд нийгэм нь амьдралыг улстөрийн объект гэж үзэхэд хүрч байна. Секс аль алинд нь чухал байдаг. "Секс бол биеийн амьдрал, төрөл зүйлийн амьдрал аль алинд нь нэвтрэх хэрэгсэл"¹. Орчин үеийн өрнөдөд секс сэтгэлээс илүү чухал болж, амьдралтай эн чацуу чухал болж байна.

Постмодернизм

Постмодернизм хэзээ үүссэн, тэр нь юу болох талаар нэгдсэн ойлголт байдаггүй. Түүнийг тодорхойлоход хүнд байдгийн учир нь тэрээр урлаг, уран барилга, хөгжим, кино, уран зохиол, харилцаа холбоо, хувцас дизайн, техник технологийг хамарсан маш олон салбарт илэрдэг юм. Постмодернизм хэзээ яг эхэлсэн нь тодорхойгүй болохоор түүнийг түүхийн хувьд, хөдөлбөргүй тогтоох боломжгүй. Постмодернизмыг авч үзэх хамгийн хялбар зам нь түүний сурвалж болсон модернизмыг эхлээд ойлгох явдал байж болох талтай. Модернизм нь постмодернизмыг ойлгсход холбогдох хоёр хэсгээс буюу тодорхойлолтын хоёр хэв маягаас бүрддэг. Нэг нь "модернизм" гэж

¹ Foucault Michel *The History of Sexuality*. Vol. 1. An Introduction. New York. Vintage, 1980, pp., 146

нэрлэгддэг астетик хөдөлгөөнөөс үүдэлтэй. Энэ бол визуаль урлаг, хөгжим, уран зохиол, жүжгийн хүрээнд гарсан хөдөлгөөн. "Дээд модернизм"-н үед буюу 1910-1930 онд яруу найраг, зохиол бүтээлийг яаж хийхэд эрс нөлөөлсөн модернист уран зохиолын гол төлөөтөгчид нь хорьдугаар зууны модернизмыг үндэслэгч хэмээгдэгч Вүүлф Жойс, Элиот, Поунд, Стэвэнс, Прүүст, Малларм, Кафка, Рилке нар юм. Уран зохиолын талаасаа модернизмын гол онцлог нь:

1. Импрессионизм ба бичлэг дэх /мөн визуаль урлаг дах/ субъектив шинжийг онцлох, ЮУГ мэдрэхээсээ илүүгээр ЯАЖ харах, унших, мэдрэхэд анхаарах. Үүний жишээ бол ухамсрын урсгал хэмээх бичлэг байж болно.
2. Бүхнийг мэдэгч гурав дах бие буюу өгүүлэгчийн бий болгох илт объектив байдал, үзлийн нарратив хөдөлгөөнгүй цэг, тодорхой хуваасан ёс суртахууны байрлалаас зайлсхийх байдал. Фолкнэрийн олон өгүүлэгчтэй туужууд үүний жишээ.
3. Төрөл зүйл хоорондын ялгааг бүдэгрүүлэх. Үүний улмаас яруу найраг нь /Элиотынх шиг/ илүү баримтын шинжтэй, өгүүлэл нь /Вүүлф эсвэл Жойсынх шиг/ яруу найргийн шинжтэй байдаг.
4. Хэсэг бусаг байдал, тасалданги өгүүлэмж, янз бүрийн зүйлийн эмх замбараагүй мэт зүйдлийг онцлох.
5. Хэсэг тус бүрт рефлексив¹ байдал, өөрийгөө ухамсарлахуйд хандах байдал. Иймд хэсэг бүхэн тодорхой байдлаар нийтлэг төрхийг бүрдүүлэх хувьдаа анхаарал татдаг.
6. Аяндаа илэрхий байх байдалд дуртай формал астетик онолыг үгүйсгэдэг.
7. "Дээд" ба "доод" буюу олон нийтийн соёл хоорондын ялгааг арилгадаг.

Постмодернизм нь модернизмын нэгэн адил дээрх санааг хуваалцаж, пастихэ /өмнөх ажлуудын арга барилыг дуурайх, янз бүрийн ажлын цоморлигоос бүрдсэн/, пароди /өрөвдөлтэй, хөөрхийрөлтэй/, бриколаж /гартаа тааралдсанаараа хийх/, егөө зэргийг онцолдог. Гэхдээ модернизм хүний субъектив байдал, түүхийн орхигдсон талыг /жишээ нь Илүүдэл газар, Гэрэлт цамхаг тийш зэргийг сана/ үзүүлэхдээ түүнд харамссан байдлыг харуулах хандлагатай /ихэнх модернистын бүтээл орчин үеийн амьдралд

¹ Өөрийгөө эргэцүүлсэн, ухаарсан гэсэн утгаар хэрэглэгдэж байна.

гээгдчихээд байгаа нэгж, зохирол, утгыг урлагийн бүтээл хангаж чадна гэсэн санаа, урлаг бол бусад институтуудын хийж чадаагүйг хийнэ гэсэн санааг илэрхийлэхийг чармайдаг/ бол постмодернизм нь тэр орхигдсон, үеэ өнгөрөөсөн, тохирохгүй байдалд харамсахгүй харин ч талархан хүлээж авдаг.

Энэ хоёрын харилцааг авч үзэх өөр нэг хандлага тэдний ялгааг үзүүлэхэд тус болно. Фредрих Жеймсонийнхоор энэ хоёр нь капитализмын тодорхой үе шатанд тохирох соёлын хэлбэршилүүд. Соёлын тодорхой практикийг тогтоодог гол гурван шат капитализмд байгааг онцолсон. Эхнийх нь Өрнөдөд, Англи, АНУ-д арван наймаас арван есдүгээр зууны сүүл хүртэл үргэлжилсэн зах зээлийн капитализм. Энэ үе технологийн дэвшил тухайлбал уурын хөдөлгүүр болон гоозүйн тодорхой төрөл жишээ нь реализмтай холбоотой байсан. Дараагийн үе нь арван есдүгээр зууны сүүлээс хорьдугаар зууны дунд /бараг дэлхийн I дайн/ хүртэл үргэлжилсэн. Монополи капитализмын энэ үе цахилгаан ба дотоод шаталтат хөдөлгүүр болон модернизмтой холбоотой. Бидний амьдарч буй гурав дах үе олон улсын буюу хэрэглээний капитализм нь цөмийн ба цахим технологи, постмодернизмтой холбоотой. Постмодерн нийгмийн дүр төрх нь дөрвөн элементээс бүрдэнэ. Нэгд, энэ нийгэм өнгөн, гүн рүү орохгүй байх байдлаар тодорхойлогддог. Алдартай жишээ нь Энди Вархолын *Кампбэлл шөлний* лаазны алдарт зураг. Постмодерн онол ёсоор энэ зураг бол эх дүр ба хуулбар хоорондоо үл ялгарах симулакрум юм. Хоёрд, хүчин мөхөс сэтгэл хөдлөлөөр тодорхойлогддог. Эдвард Мүүнхийн *Хашхираан* бол гүн цөхрөлөө илэрхийлж байгаа хүний тухай сюрреалист зураг. Постмодерн ертөнц саланги тусдаа болсон болохоор нөлөөлөл нь "чөлөөтэй урссан, хувийн бус"¹ шинжтэй. Гуравт, түүхэн шинжийн алдагдал. Бид өнгөрсөнийг мэдэж чадахгүй. Бидний хандсан бүхэн өнгөрсөний тухай текст байдаг бөгөөд бидний хийж чадах зүйл бол энэ сэдвээр арай өөр текст бүтээх явдал. Энэ нь "өнгөрсөний бүх хэв маягийн зоргоор ганнибализаци"²-д хөтөлдөг. Үр дүн нь пастихе. Нэгэнт өнгөрсөний тухай үнэнийг олж, тохирох дүр зурагийг нь гаргаж чадахгүй учраас пастихе бүтээхээр сэтгэл ханадаг. Мөн түүхэн хөгжил, цаг хугацааны чиглэлийн талаар иэлрхий утга байдаггүй. Өнгөрсөн одоо хоёр эцэс төгсгөлгүй орооцолдсон байдаг. Э.Л.Докторовын

¹ Jameson Fredric *Postmodernism, or the Cultural Logic of Late Capitalism*, New Left Review, 1984, pp., 64.

² Jameson Fredric *Postmodernism, or the Cultural Logic of Late Capitalism*, New Left Review, 1984, pp., 65-66

Ragtime-аас үүнийг сайтар харж болно. Өнгөрсөн, одоо, ирээдүйг зааглах боломжгүй энэ байдал хувь хүний төвшинд нэгэн төрлийн шизофренийг илтгэж байна. Постмодерн хувь хүн, үйл явдал салангид, тасархай байна. Дөрөвт, энэ нийгэмтэй холбоотой шинэ технологи.

Энэ тодорхойлолт бол уран зохиол, урлаг гэхээсээ түүх, нийгэм дээр тулгуурлаж буй юм. Уг хандлага постмодернизмыг нийгмийн нэг хэлбэршилийн нэр буюу нийгэм/түүхийн цогц хандлага гэж тодорхойлдог. Тодруулбал энэ хандлага постмодернизмыг модернизмтай биш харин постмодерн үеийг модерн үетэй харьцуулдаг. Модерн буюу орчин үе нь европын гэгээрлийн үетэй холбоотой. Соён гэгээрлийн гол санаа нь гуманизмын үндсэн санаатай ижил:

1. Би нь ухамсар, рациональ, автономии, түгээмэл юм.
2. Би нь өөрийгөө болон ертөнцийг оюуны хамгийн дээд функци, объектив хэлбэр болох оюун ухаан буюу рациональ байдлаар танин мэддэг.
3. Рациональ объектив би-гээр бүтсэн танин мэдэхүйн хэлбэр нь танин мэдэгчийн хувийн статусаас үл хамаарах, ертөнцийн талаарх түгээмэл үнэнг хангах "шинжлэх ухаан" юм.
4. Шинжлэх ухааны бүтээсэн мэдлэг үнэн бөгөөд хувирашгүй.
5. Шинжлэх ухааны бүтээсэн мэдлэг/үнэн нь үргэлж хөгжил дэвшил, төгөлдөржилт рүү хөтөлнө.
6. Оюун ухаан юу үнэн болохыг эцэслэн шийдэх учраас аль нь зөв, аль нь сайн гэдгийг бас шийднэ.
7. Оюун ухаанаар удирдагдсан ертөнцөд үнэн ямагт сайн хийгээд зөвтэй адил байна. Үнэн юм, зөв юм хоёрын хооронд зөрчил байхгүй.
8. Иймд шинжлэх ухаан мэдлэгийн бүх хэрбэрийн эх загвар болно. Шинжлэх ухаан нейтрал бөгөөд объектив. Рациональ чадвараараа шинжлэх ухааны мэдлэгийг бүтээдэг эрдэмтэн хүн оюун ухааны хуулийг дагах эрхтэй бөгөөд өөр зүйлд /мөнгө, эрх мэдэл гэх мэтэд/ татагддаггүй.
9. Мэдлэгийг илэрхийлэх хэл бас рациональ байх ёстой. Рациональ байхын тулд хэл ойлгомжтой байх ёстой. Хүртэхүйн объект, түүнийг нэрлэхэд хэрэглэгдэх үг хооронд нарийн чанд, объектив харилцаа байх ёстой.

Тэгэхээр постмодернизм юуны өмнө энэ бүхний эсрэг гэсэн үг. Мөн агуу нарратив буюу метанарративын санааг үгүйсгэдэг. Жишээ нь, Лиотард

орчин үеийн /шинжлэх ухааны/ мэдлэгийг нэг төрлийн агуу синтезтэй адилтгасан. Орчин үеийн шинжлэх ухаантай холбосон тэр агуу нарратив нь "Оюун санааны диалектик, утгын хөрмөнөвт, ухаалаг, ажилчин субъектыг дарлалаас чөлөөлөх, баялаг бүтээх"¹ зэргийг багтаадаг. Метанарративт үл итгэхийг постмодерн гэж бас тодорхойлдог. Гостмодерн мэдлэг бол эрх мэдлийн зэвсэг төдий биш. Тэр ялгааг мэдрэх мэдрэмжийг маань хурцалж, харилцан үл тохирох байдлыг хүлцэх чадварыг маань батжуулна².

Бүтээгдэхүүний толь бүтээлдээ Бодриард эдийн засгийн солилцооны альтернатив символик сололцоог авч үзсэн. Өдгөөгийн нийгэм бүтээгдэхүүнд биш харин "медиа, кибернетик загвар, компьютер, мэдээлэл боловсруулалт, үзвэр, мэдлэгийн үйлдвэрлэл гэх мэт"-д ноёлуулж байна. Бүтээгдэхүүний төрөл зүйл голлосон нийгмээс бүтээгдэхүүний кодоор удирддагдсан нийгэмд шилжсэн гэсэн үг. Ашиглалт, үр ашгаас тэмдэг, түүнийг бүтээдэг системийн ноёрхол руу анхаарал шилжлээ. Мөн тэмдэг бодит ямар нэг зүйлийг илэрхийлдэг цаг үе байсан бол одоо тэмдэг өөрсдөдөө болон өөр тэмдэгт арай мэрий хамаардаг болжээ. Өөрөөр хэлбэл тэмдэг өөрийгөө л илэрхийлж, өөрийгөө төлөөлөх, өөртөө хамаарах болсон. Бид юу бодитойг хэлж чадахгүй. Тэмдэг бодит байдал хоорондын ялгаа багасч, үгүй болж байна. Постмодерн ертөнц симуляциар тодорхойлогджээ. Бид "симуляцийн эрин үе"-д амьдарч байна. Симуляцийн процесс симулякрыг буюу "объект, үйл явдлын хуулбарыг" бүтээдэг. Ингэснээр бодит байдлын хуулбараас бодит байдлыг ялгах бэрхшээл үүсч байна. Жишээ нь, тэрээр "телевиз амьдралд уусах, амьдрал телевизд уусах" тухай ярьдаг³. Эцсийн дүндээ энэ бол бодит байдлын төлөөлөл, симулякр. Бид "эхлэл, төгсгөлгүй мушгиа, тсийрог системийг бүрдүүлдэг" эдгээр симулякрын боолчлолд байна. Энэ ертөнцийг хэт буюу hyper бодит байдал гэж тодорхойлсон. Жишээ нь медиа бодит байдлын толь байхаа болж, харин бодит байдал болж, бодит байдлаас илүү бодитой болж байна. Энэ бүхнээс болж тэрээр олон нийтийн, "сүйрлийн" хувьсгалыг туулж байгаа соёлд анхаарсан. Уг хувьсгал тэмцэгч гэхээсээ илүүгээр улам бүр идэвхгүй болж буй массыг олшруулж байна. Ийн масс "бүх утга, мэдээлэл, харилцаа, мэдээ гэх мэтийг залгин тэднийг утгагүй болгогч хар нүх" гэж үзэгдэнэ⁴. Үл

¹ Lyotard Jean-Francois *The Postmodern Condition*. Minneapolis: University of Minnesota Press, 1984, pp. xxiii

² Lyotard Jean-Francois *The Postmodern Condition*. Minneapolis: University of Minnesota Press, 1984, pp. xxv

³ Baudrillard Jean *Simulations*. New York: Semiotext(e), 1983, pp. 55

⁴ Ritzer George *Sociological Theory*. McGraw-Hill, 1996, pp. 618

ялгарал, хайхрамжгүй үл тоосон байдал, инерц бол медиа тэмдэг, симулакр, хэт бодит байдалд автсан массыг тодорхойлох нэр томъёо. "Инерцийн хурдатгал, утга нь медиад замхрах, социаль нь масст уусах, масс нь нигилизм, утга учиргүйдлийн хар нүх болон хумигдах, энэ бүхэн бол Бодриярдын постмодерн зөн"¹.

Философид постмодернизм хэмээх нэр томъёо постструктурализм, деконструкционизм, мультикультуризм, жендер судлал, уран зохиолын онол зэргийг багтаасан бүхэл бүтэн хөдөлгөөнийг илэрхийлнэ. Энэ нь 1950-иад онд позитивизм гэх мэт сургаалийн шүүмжлэл болж гарч ирсэн бөгөөд эрх мэдлийн харилцааны нөлөө, хувь хүн, үнэн болон ертөнцийг үзэх үзлийн "тогтолцоон" дах дискурсийг онцолсон. Эл үндсэн дээр түүнийг соён гэгээрлийн уламжлалын эсрэг, өрнийн философийн радикал критицизм гэж үнэлдэг.

Постструктурализм, постмодернизм хсёрыг зарим тохиолдолд илэрхий заагладаггүй ч соён гэгээрлийн уналтанд хандах байдлаараа энэ хоёр эрс ялгардэг. Постструктурализм үүнд амбивалент байдлаар ханддаг бол постмодернизм эрс талархан ханддаг. Энэ хоёр хандлага мөн чанараараа ялгаатай. Нэг нь хүн, хэл, нийгэм зэрэг өөр бусад олон асуудлыг хамарсан философи хандлага болохоос эрин үеийг төлөөлдөггүй. Гэтэл нөгөөх нь орчин үеийн дараа гарч ирж буй түүхэн үе, постмодерн үетэй салшгүй холбоотой байдаг.

Summary

According to structuralist theory, meaning is not a private experience, but the product of a shared system of signification. The individual is more a product of the system than a producer of it. There is no natural bond between words and things; there can be no privileged connection between language and reality. In this sense, reality is also produced by language. Structuralist theory removes the human subject from its central position in the production of meaning. And since language pre-exists us, it is not we who speak, but 'language speaks us'.

However, according to the poststructuralist, the specification of meaning is an infinite and endless process. Meaning is the result of a play of difference-a movement which brings about both difference and deferral. It is in constant flux or movement, therefore we could not find the ultimate meaning. We can see our own truth in it. In this sense, we all are free to be authors.

¹ Kellner Douglas Jean Baudrillard: *From Marxism to Postmodernism and Beyond*. Cambridge: Polity Press. 1989. pp.118

Emerging, in part, out of poststructuralism is an enormously influential development known as postmodernism. The postmodernist theory states that the sign cease to be a mirror of reality, but become that reality, or even more real than that reality. Furthermore, while there was a time when the signs stood for something real, now they refer to little more than themselves and other signs; signs have become self-referential.

Ном зүй

1. Godelier Maurice *Rationality and Irrationality in Economics*. London: NLB. 1972
2. Derrida Jacques *Writing and Difference*. Chacago: University of Chicago Press, 1978
3. Sheridan Alan *Michel Foucault: The Will to Truth*. London, Tavistock, 1980
4. Foucault Michel *The History of Sexuality*. Vol. 1, An Introduction. New York. Vintage, 1980
5. Jameson Fredric *Postmodernism, or the Cultural Logic of Late Capitalism*. New Left Review. 1984
6. Lyotard Jean-Francois *The Postmodern Cor.dition*. Minneapolis: University of Minnesota Press, 1984
7. Baudrillard Jean *Simulations*. New York: Serniotext(e). 1983
8. Ritzer George *Sociological Theory*. McGraw-Hill., 1996
9. Kellner Douglas *Jean Baudrillard: From Marxism to Postmodernism and Beyond*. Cambridge: Polity Press. 1989